

САНГИЙН САЙД, ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2016 оны 4 дугаар
сарын 26 ны өдөр

Дугаар 152 / 101

Улаанбаатар хот

Суурь норм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, "Авто замын тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Авто зам, гүүрийн арчлалт, засварын ажлын зардлын суурь норм" /УББ 80-201-16/-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү нормыг техник, технологийн дэвшил болон эдийн засгийн инфляцийн түвшинтэй уялдуулж, суурь нормын индексийг жил бүр тооцож, нормыг мөрдүүлэхийг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д даалгасугай.

3. Уг нормын дагуу авто зам, гүүрийн арчлалт, засварын ажлыг төлөвлөн, хөрөнгө оруулалтад тусгаж байхыг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Х.Ганцогт/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Дэд бүтцийн хөгжлийн сайд, Сангийн сайдын 2000 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн суурь үнэлгээ, цагийн тариф батлах тухай 139/83 дугаартай хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САНГИЙН САЙД
Б.БОЛОР

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД
М.ЗОРИГТ